


**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Биелэлт
Нэг.Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр					
4.1.1.1.төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилно.	Жилдээ	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байх	Авилгатай тэмцэх газарт нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг мэдүүлсний үндсэн дээр тус газраас ирүүлсэн хяналт дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилдог. АТГ-аас зохион байгуулсан сургалтанд ажилтан албан хаагчид бүгд хамрагдан оролцсон.
4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ес зүй, мэдлэг, боловсрол, туршлага, үр чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	4	Албан тушаалтанд тавигдах ес зүй, мэдлэг, боловсрол, туршлага, үр чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно	Жилдээ	Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан иргэнийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилсон байх	Албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлагыг хангасан иргэдээс мэдлэг боловсрол, үр чадвар, туршлагаар нь сонгон шалгаруулж томилдог.
	5	Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулна.	Жилдээ	Төрийн албаны нөөц нэмэгдсэн байх	Албан хаагчид өөрсдийн мэдлэг чадвараа бататгах, хууль эрх зүйн боловсролоо дээшлүүлэх үүднээс Хуульчийн мэргэжлийн шалгалтад 1 албан хаагч оролцсон. Залуу боловсон хүчнүүдээ шат дараатайгаар төрийн албаны шалгалтад бэлтгэн оролцуулахаар төлөвлөн ажиллаж байна.


4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	7	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ.	Жилдээ	Өргөдөл, гомдол, мэдээллийг шалгах ёс зүйн зөвлөл, хяналт, шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх	2023 оны жилийн эцсийн байдлаар удирдлага болон албан хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй болно.
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгэг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр					
4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэдбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх	16	Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулна.	Жилдээ	Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулсан байх	Байгууллагын удирдлагад иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг цаасаар болон цахим хэлбэрээр хүлээн авч хууль тогтоомжийн хүрээнд, шуурхай шийдвэрлэн мэдээ тайланг байгууллагын Даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлэн НЗДТГ-т хүргүүлдэг.

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
2023 оны 12 дугаар сарын 28 –ны өдөр



Н.ПҮРЭВСҮРЭН

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.БОЛОРТУЯА